



НИЙСЛЭЛИЙН ӨМЧИЙН ХАРИЛЦААНЫ ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2025 оны 11 сарын 11 өдөр

Дугаар А/СЧТ

Улаанбаатар хот

Нийслэлийн хүүхдийн 259 дүгээр цэцэрлэгийн данс бүртгэлд хөрөнгө бүртгэх тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсгийн 4 дэх заалт, 75 дугаар зүйлийн 75.1 дэх хэсэг, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолоор баталсан “Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам”-ын 1 дүгээр зүйлийн 1.3 дахь хэсэг, 3 дугаар зүйлийн 3.2.3 дахь заалт, Нийслэлийн Өмчийн харилцааны газрын даргын 2025 оны А/126 дугаар тушаалаар байгуулагдсан “Үндсэн хөрөнгийн хөдөлгөөн хариуцсан комисс”-ын 2025 оны 11 дүгээр сарын 04-ний өдрийн 11 дүгээр хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Эцэг эхчүүдээс хандивласан нийт 800,000.00 (найман зуун мянга) төгрөгийн үнэ бүхий хавсралтад заасан эргэлтийн бус хөрөнгийг данс бүртгэлд бүртгэн авахыг Нийслэлийн хүүхдийн 259 дүгээр цэцэрлэг (Ц.Батцэцэг)-т зөвшөөрсүгэй.

2.Өмчийн мэдээллийн санд хөрөнгийн хөдөлгөөний холбогдох өөрчлөлт хийж ажиллахыг Нийслэлийн хүүхдийн 259 дүгээр цэцэрлэг (Ц.Батцэцэг)-т үүрэг болгосугай.

3.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа, удирдлагын хэлтэс (Т.Оюунтуул)-т даалгасугай.

ДАРГА *В.Оюумаа* В.ОЮУМАА



Нийслэлийн Өмчийн харилцааны газрын
 2025 оны 11 дүгээр сарын 11-ний
 өдрийн 13.11 дугаар тушаалын хэвсралт



Бүртгэх хөрөнгийн жагсаалт

Байгууллагын нэр: Нийслэлийн хүүхдийн 259 дүгээр цэцэрлэг

№	Эд хөрөнгийн нэр	Ашиглалтанд орсон	Чанар байдал	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Бүртгэх үнэ		Хандив
						Нэгжийн үнэ	Нийт үнэ	
1	Зурагт LG 50 инч	2025	шинэ	ш	1	800,000.00	800,000.00	Нэр
Бүртгэх хөрөнгийн нийт дүн							800,000.00	Эцэг эхчүүд
								Хандив